

“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4-р сарын 30-ны өдөр

№1

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Уужим хангай” ХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.



ХУРЛЫН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4-р сарын 30-ны өдөр

№2

Улаанбаатар хот

Компанийн үнэт цаасны арилжааг сэргээх тухай

“Уужим хангай” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3-р сарын 28-ны өдрийн 77-р тогтоолын 4-р заалтын дагуу компанийн үнэт цаасны арилжааг СЭРГЭЭСҮГЭЙ.
2. Компанийн үнэт цаасны арилжааг сэргээх ажиллагааг холбогдох хууль журмын дагуу явуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд ДААЛГАСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ



“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4-р сарын 30-ны өдөр

№3

Улаанбаатар хот

Компанийг өөрчлөн байгуулах, харъяалал болон хаягийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 62.1.2-р заалт, “Уужим хангай” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн дагуу “Стандарт агрикалчер групп” ХХК-ийг компанид НЭГТГЭСҮГЭЙ.
2. Компани нэгтгэж, компанийг өөрчлөн байгуулахтай холбоотой компанийн албан ёсны харъяалал болон хаягийг нэгдэж буй “Стандарт агрикалчер групп” ХХК-ийн хаягаар ӨӨРЧИЛСҮГЭЙ.
3. Компани нэгтгэсний дараа “Уужим хангай” ХК-ийн оноосон нэрийг “Стандарт агрикалчер групп” гэж өөрчлөхийг ЗӨВШӨӨРСҮГЭЙ.
4. Компани нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.
5. Компанийн харъяалал болон хаягийг өөрчлөн, хууль журмын дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ



**“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4-р сарын 30-ны өдөр

№4

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах заалт, “Уужим хангай” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан
 - Г.Лхамсүрэн
 - Г.Хатанболд
 - Д.Баярсайхан
 - Л.Золбаяр
 - С.Шагдарсүрэн
 - Б.Ундрал

нарыг Ердийн гишүүнээр,

- Д.Санжид
- Ц.Оюунгэрэл
- Б.Амгаланбаатар

нарыг Хараат бус гишүүнээр СОНГОСУГАЙ.

2. Компанийн үр ашигтай ажиллагааг хууль журмын дагуу удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд **ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ



**“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4-р сарын 30-ны өдөр

№5

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1-дэх заалт, “Уужим хангай” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Уужим хангай” ХК-ийн дүрмийн 7.23-р заалтад ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа “3 жил” гэснийг “1 жил” болгон **ӨӨРЧИЛСҮГЭЙ.**
2. Энэ өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулж, Улсын бүртгэлд хуульд заасан хугацаанд бүртгүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд **ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА



..... Б.ЭНХЖАРГАЛ

“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4-р сарын 30-ны өдөр

№6

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Уужим хангай” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Уужим хангай” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2014 онд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэснийг БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ

